

**“АТАР-ӨРГӨӨ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

---

2021 оны 04 сарын 27 -ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

Атар-Өргөө ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын “Хурлын ирц, хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай” 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 01, “Саналын хуудсаар санал өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын комиссын дүнгийн тухай” 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус баталсугай.



ХУРЛЫН ДАРГА

Б.МӨНХДАЛАЙ

**“АТАР-ӨРГӨӨ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

---

2021 оны 04 сарын 27 -ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

Атар-Өргөө ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч, баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд дэвшүүлсэн саналыг хэрэгжүүлж ажиллахыг шинээр сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



*Б.Мөнхдалай*  
Б.МӨНХДАЛАЙ

**“АТАР-ӨРГӨӨ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

---

2021 оны 04 сарын 27 -ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРИЙГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ**

Компанийн хувьцаа эзэмшигчдэд “Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тухай” Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03 тогтоол)-г хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

“Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тухай” Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр (2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03 тогтоол)-ийг зөвшөөрсүгэй.

  
ХУРЛЫН ДАРГА Б.МӨНХДАЛАЙ

**“АТАР-ӨРГӨӨ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

---

2021 оны 04 сарын 27 -ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭР СОНГОГДСОНЫГ БАТАЛЖ,  
БҮРЭН ЭРХИЙГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, компанийн Дүрмийн “Долоо”-ын 7.22 дахь заалт, хувьцаа эзэмшигчдээс кумулятив аргаар өгсөн санал, Тооллогын комиссын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

Дор дурдсан хүмүүсийг Атар-Өргөө ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн ба хараат бус гишүүнээр сонгогдсоныг баталж, бүрэн эрхийг зөвшөөрсүгэй. Үүнд:

Ердийн гишүүнээр

Бэрэнбаралын Мөнхдалай  
Бэрэнбаралын Ганбат  
Жамцын Сайнбилэг  
Ганзоригийн Баттулга  
Ганзоригийн Энхболд  
Мөнхдалайн Мөнхтэнгис

Хараат бус гишүүнээр

Сүхбаатарын Бямбахорлоо  
Тогоогийн Жигмэддагва  
Пүрэвийн Болормаа

ХУРЛЫН ДАРГА



Б.МӨНХДАЛАЙ

**“АТАР-ӨРГӨӨ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

---

2021 оны 04 сарын 27 -ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЦАЛИН, ДОТООД АЖЛЫН  
ЗАРДЛЫН ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

Атар-Өргөө ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалингийн хэмжээ болон дотоод ажлын зардлын төсвийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн санал, Тооллогын комиссын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, дотоод ажлын зардлын төсөв”-ийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.



ХУРЛЫН ДАРГА

A handwritten signature in black ink, appearing to be "B. Mönхдалай".

Б.МӨНХДАЛАЙ



**“АТАР-ӨРГӨӨ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

---

2021 оны 04 сарын 27 -ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

**СОНГУУЛЬТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь заалт, Тоологын комиссын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон Л.Бямбажаргал, Б.Бадамжаргал нарын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгуульт ажлаас чөлөөлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.МӨНХДАЛАЙ